

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРВИ СУМЫН ЕБС-ИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/155/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: AzzayaTs@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЕБС</i>	<i>Ерөнхий боловсролын сургууль</i>
<i>НДШ</i>	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
<i>ХАОАТ</i>	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>
<i>СТСХ</i>	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
<i>БСШУЯ</i>	<i>Боловсрол соёл шинжлэх ухааны яам</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audt.gov.mn

ДАРВИ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАЯРДАЛАЙ ТАНАА

2021.03.16 № 2/154
танай -нм № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, суралцагчийн сурлагын түвшин зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Дарви сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй /хоол хүнсний материал/, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй, үндсэн хөрөнгийн бүртгэлийг багц дүнгээр бүртгэсэн, заалны түрээсийн орлого зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох эрхзүйн актуудтай нийцэхгүй, аудитын "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020680

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>106710078.0</u>	<u>115079347.0</u>
33	АВЛАГА	221361.0	0.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	221361.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	106488717.0	115079347.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.0	1302000.0
354	Хангамжийн материал	105300717.0	112589347.0
35460	Хүнсний материал	2110690.0	9399320.0
35470	Бусад хангамжийн материал	103190027.0	103190027.0
35600	Мал амьтад	1188000.0	1188000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2559389369.8</u>	<u>2573229945.3</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2559389369.8	2573229945.3
392	Биет хөрөнгө	2477337369.8	2489927945.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	2326367741.0	2326367741.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-66187097.9	-125791121.5
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20000000.0	0.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20000000.0	0.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	233758846.5	283778861.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-187952849.3	-203857712.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142057351.0	193526999.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89752734.1	-97298705.3
39214	Бусад үндсэн хөрөнгө	86206763.9	86206763.9
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8483962.7	-16967925.2
39217	Ном	41323311.4	43963045.3
393	Биет бус хөрөнгө	82052000.0	83302000.0
39301	Програм хангамж	0.0	1250000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	82052000.0	82052000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2666099447.8</u>	<u>2688309292.3</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4092000.0</u>	<u>2850000.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4092000.0	2850000.0
413	Өглөг	4092000.0	2850000.0
4136	Бусад өглөг	4092000.0	2850000.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4092000.0	2850000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2662007447.8</u>	<u>2685459292.3</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2662007447.8	2685459292.3
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1103560457.5	1103560457.5
51101	Өмч: - төрийн	1103560457.5	1103560457.5
512	Хуримтлагдсан үр дүн	88738825.1	112190669.6
51210	Өмнөх үеийн үр дүн	88738825.1	88738825.1
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	23451844.5

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1469708165.2	1469708165.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2666099447.8	2688309292.3

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	950561484.0	1205190596.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20839199.0	104723396.4
120	Нийтлэг татварын бус орлого	20839199.0	104723396.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20839199.0	104723396.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400000.0	400000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20439199.0	104323396.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	929722285.0	1100467200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	859809700.0	996512500.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	859809700.0	996512500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40882185.0	8799300.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32595000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5137385.0	8799300.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3149800.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29030400.0	95155400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29030400.0	95155400.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	995387610.7	1181738751.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	995387610.7	1181738751.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970538976.7	1128069160.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686872175.0	797960196.4
210101	Үндсэн цалин	476297095.0	541365614.0
210102	Нэмэгдэл	124247880.0	177065686.0
210104	Урамшуулал	52230100.0	64515278.0
210105	Гэрээт ажлын хөлс	34097100.0	15013618.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85844605.0	83101821.6
210201	Тэтгэврийн даатгал	85844605.0	67499021.4
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	7837865.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	6263572.6
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	1501361.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22666100.0	91658900.0
210301	Гэрэл, цахилгаан	6576667.0	4722002.0
210302	Түлш, халаалт	15989433.0	86936898.0
210303	Цэвэр, бохир ус	100000.0	
2104	Хангамж, бараа материалын зардал	5077562.0	6777042.0
210401	Бичиг хэрэг	399875.0	1310200.0
210402	Тээвэр, шатахуун	2049597.0	2320200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	439400.0	623000.0

210404	Ном, хэвлэл	175900.0	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	611600.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1401190.0	2523642.0
2105	Нормативт зардал	54969576.0	31817020.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	313300.0	4752300.0
210502	Хоол, хүнс	53547776.0	23875420.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1108500.0	3189300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3527350.0	3684770.0
210604	Урсгал засвар	3527350.0	3684770.0
2107	Томилолт, зочны зардал	2286630.0	516000.0
210702	Дотоод албан томилолт	2286630.0	516000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1261363.0	720000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	477363.0	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	784000.0	720000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108033615.7	111833410.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11834345.0	17587360.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5522438.0	2707230.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90676832.7	91538820.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24848634.0	53669591.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	24848634.0	32669703.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.0	255935.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24848634.0	14335156.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	18078612.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	20999888.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	20999888.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-44826126.7	23451844.5
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-44826126.7	23451844.5

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	930,122,285.0	1,100,867,200.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,000.0	400,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	400,000.0	400,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	400,000.0	400,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.0	400,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	929,722,285.0	1,100,467,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	859,809,700.0	996,512,500.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	859,809,700.0	996,512,500.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,882,185.0	8,799,300.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,595,000.0	

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,137,385.0	8,799,300.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,149,800.0	
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,030,400.0	95,155,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,030,400.0	95,155,400.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>915,711,885.0</u>	<u>1,099,811,200.0</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,711,885.0	1,099,811,200.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,362,885.0	1,044,343,137.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,334,574.0	777,015,940.0
210101	Үндсэн цалин	472,298,474.0	578,596,062.0
210102	Нэмэгдэл	118,388,800.0	167,991,086.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	47,507,900.0	30,428,792.0
210105	Гэрээт ажлын хөлс	43,139,400.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,677,600.0	103,333,787.0
210201	Тэтгэврийн даатгал	57,580,700.0	103,333,787.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,774,200.0	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,419,400.0	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,354,900.0	-
210205	Эрүүл мэндийн даатгал	13,548,400.0	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,532,100.0	95,155,400.0
210301	Гэрэл, цахилгаан	6,588,400.0	8,218,502.0
210302	Түлш, халаалт	17,843,700.0	86,936,898.0
210303	Цэвэр, бохир ус	100,000.0	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,847,185.0	6,539,600.0
210401	Бичиг хэрэг	489,800.0	489,800.0
210402	Тээвэр, шатахуун	1,994,985.0	2,084,400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	520,000.0	623,000.0
210404	Ном, хэвлэл	435,400.0	435,400.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,800.0	235,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,171,200.0	2,671,200.0
2105	Нормативт зардал	55,552,426.0	40,365,650.0

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	313,300.0	4,752,300.0
210502	Хоол, хүнс	53,936,426.0	32,424,050.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,302,700.0	3,189,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,703,100.0	-
210604	Урсгал засвар	4,703,100.0	-
2107	Томилолт, зочны зардал	317,500.0	516,000.0
210702	Дотоод албан томилолт	317,500.0	516,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	226,800.0	720,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	226,800.0	720,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,171,600.0	20,696,760.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,200,500.0	17,696,160.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,971,100.0	3,000,600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,349,000.0	55,468,063.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,349,000.0	34,468,175.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	255,935.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,349,000.0	16,133,628.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18,078,612.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	20,999,888.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	20,999,888.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,410,400.0	1,056,000.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,410,400.0	1,056,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,410,400.0	1,056,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	14,410,400.0	1,056,000.0
223001	Бусад хөрөнгө		1,056,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,410,400.0	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,410,400.0)	(1,056,000.0)

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,560,457.5	1,469,708,165.2	133,564,951.8	2,706,833,574.6

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,103,560,457.5	1,469,708,165.2	133,564,951.8	2,706,833,574.6
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(44,826,126.7)	(44,826,126.7)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,560,457.5	1,469,708,165.2	88,738,825.1	2,662,007,447.8
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,103,560,457.5	1,469,708,165.2	88,738,825.1	2,662,007,447.8
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,103,560,457.5	1,469,708,165.2	88,738,825.1	2,662,007,447.8
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	23,451,844.5	23,451,844.5
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,103,560,457.5	1,469,708,165.2	112,190,669.6	2,685,459,292.3

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1092067900.0	1071068012.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1092067900.0	1071068012.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1065072500.0	1036599837.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	798652600.0	777015940.0
210101	Үндсэн цалин	527919200.0	578596062.0
210102	Нэмэгдэл	215301900.0	167991086.0
210104	Урамшуулал	55431500.0	30428792.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107818200.0	103333787.0
210201	Тэтгэврийн даатгал	107818200.0	103333787.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95155400.0	95155400.0
210301	Гэрэл, цахилгаан	7247200.0	8218502.0
210302	Түлш, халаалт	87908200.0	86936898.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5039600.0	5039600.0
210401	Бичиг хэрэг	489800.0	489800.0
210402	Тээвэр, шатахуун	2084400.0	2084400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	623000.0	623000.0
210404	Ном, хэвлэл	435400.0	435400.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235800.0	235800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1171200.0	1171200.0
2105	Нормативт зардал	53042100.0	40365650.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4752300.0	4752300.0
210502	Хоол, хүнс	45100500.0	32424050.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3189300.0	3189300.0
2107	Томилолт, зочны зардал	317500.0	516000.0
210702	Дотоод албан томилолт	317500.0	516000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392000.0	720000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392000.0	720000.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4655100.0	14453460.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400000.0	10396860.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4255100.0	4056600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26995400.0	34468175.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26995400.0	34468175.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.0	255935.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26995400.0	16133628.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	18078612.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1092067900.0	1071068012.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	996512500.0	975512612.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	996512500.0	975512612.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	95155400.0	95155400.0
132001	Орон нутгийн төсвөөс	95155400.0	95155400.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	400000.0	400000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400000.0	400000.0

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40882185.0	8799300.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40882185.0	8799300.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40882185.0	8799300.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3913774.0	0.0
210101	Үндсэн цалин	3913774.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	137385.0	1500000.0
210402	Тээвэр, шатахуун	137385.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.0	1500000.0
2105	Нормативт зардал	1086226.0	0.0
210502	Хоол, хүнс	1086226.0	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35744800.0	7299300.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32595000.0	7299300.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3149800.0	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40882185.0	8799300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40882185.0	8799300.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32595000.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5137385.0	8799300.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3149800.0	

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Дарви сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Б.Баярдалай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, шилэн данс, үндсэн хөрөнгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага
- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дарви сумын ЕБС-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БСШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналтыг 2020 онд тус байгууллагад хэрэгжүүлээгүй ч аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт хийж 2021 оны 2 дугаар сард 5 зөрчилд 8610.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож актыг барагдуулах хугацаа болоогүй байна. Мөн сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Дарви сумын ЕБС-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 845043.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8450.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1205190.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 12054.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дарви сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22209.8 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	221.1	0	-221.1
Урьдчилгаа			0
Бараа материал	106488.7	115079.3	8590.6
Үндсэн хөрөнгө	2559389.3	2573229.9	13840.5
Нийт хөрөнгө	2666099.4	2688309.2	22209.8
Өр төлбөр	4092.0	2850.0	-1242.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2662007.4	2685459.2	23451.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2666099.4	2688309.2	22209.8

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 0 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 115079.3 мянган төгрөг болж 8590.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хүнсний материал буюу мах их хэмжээгээр нөөцөлсөн байгаа нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2559389.3 мянган төгрөг, оны эцэст 2573229.9 мянган төгрөг болж 13840.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 1056.0 мянган төгрөг, БСУГ-аас ирсэн үнэ төлбөргүй бараа материал 83573.7 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19499.6 мянган төгрөгийн сандал ширээ, 1250.0 мянган төгрөгийн санхүүгийн программ үнэ төлбөргүй орлогоор, аймгийн ИТХ-ын 2020.04.24-ны 115 тоот тогтоолоор 20000.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр оны эхэнд хувь хүмүүст төлөх 4092.0 мянган төгрөг байсан ба тайлант онд 1120802.8 төгрөгийн өр үүсэж 1122044.8 барагдуулсан бөгөөд тайлант оны эцэст 2850.0 мянган төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна. Энэ үлдэгдлийн 1000.0 мянган төгрөг нь номны үнэ, 1850.0 мянган төгрөг нь саадан хашааны үлдэгдэл төлбөрийн өглөг бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 2685459.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 23451.8 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Дарви сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 254629.1 мянган төгрөгөөр буюу 26.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 254629.1 мянган төгрөгийн орлогоос 254629.1 мянган төгрөг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 186351.1 мянган төгрөгөөр буюу 18.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 186351.1 мянган төгрөгийн зардал нь цалингийн зардал 111088.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 75263.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1092067.9 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1092067.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 996512.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 95155.4 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогыг 400.0 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 1092067.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1092067.9 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 996512.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 95155.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 400.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 996512.5 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 975512.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 95155.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 400.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 1071068.01 мянган төгрөг зарцуулж 20999.8 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1071068.01 мянган төгрөг буюу 98% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7786.5
81806	Хоол хүнс	4187.7
81801	Үдийн цай хөтөлбөр	9025.6
	ДҮН	20999.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар номын түрээсээр 3189.3, сумын ОНХС-аас 4500.0, тусгаарлах байрны төлбөр 960.0, ЗДТГ-аас урамшуулал 150.0, нийт 8799.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 3189.3 мянган төгрөгийн номын түрээс төвлөрүүлж, 4500.0 мянган төгрөгийг сургуулийн лаборатори, хичээлийн хэрэглэгдэхүүнд авахад, 1110.0 мянган төгрөгийг ариутгал, халдваргүйжүүлэлт бусад зардалд тус тус гаргасан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 105, мэдээллийг хугацаа хоцроож оруулсан 44 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулснаас санхүүжилтийн 3 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дарви ЕБС нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	8340.0	1	8340.0	0	0	100
Албан шаардлага	1	564359.9	0	0		564359.9	0
Нийт дүн	1	572699.9	1	8340.0	0	564359.9	50

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан боловч албан шаардлагын биелэлт хангагдаагүй 104378.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч, тайлант онд 97114.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч 2 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 97114.8 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар цалингийн нэмэгдлийн тушаал шийдвэрийн хэрэгжилтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл

- 1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд хандив, тусламж, хөрөнгө оруулалтаар ирсэн лабораторийн төхөөрөмж, ор, ширээ, сандлыг нэр төрлөөр ангилж бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд орлого аваагүй багц дүнгээр орлого авч бүртгэсэн байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Хандив тусламж, хөрөнгө оруулалтаар ирсэн ор, сандал ширээ, лабораторийн төхөөрөмжийг нэр төрлөөр ангилж бараа материал, үндсэн хөрөнгийн шинжтэйгээр ялгаж орлого авч бүртгэж залруулах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Хүнсний материал

- 2.1. Илрүүлэлт: Хүнсний бүтээгдэхүүн болон мах гарал үүслийн бичиггүй, махны нөөц их хэмжээтэй, зарим хүүхдийн хоолны талонд огноо, хүүхдийн тоо, хүнсний материалын нэр засвартай бичигдсэн зэрэг 8535.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- 2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хангагдахгүй байх
- 2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хэрэгцээнээс илүү мах нөөцлөхгүй байхад анхаарч, хоол хүнсний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Заалны орлого

3.1 Илрүүлэлт: Тайлант онд заалны түрээсээр орсон орлогыг төсөвт төвлөрүүлж зарцуулаагүй байна.

3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хангагдахгүй байх

3.3 Өгсөн зөвлөмж: Заалны түрээсийн орлогын тооцоог бодож, түрээсээр орох орлогыг холбогдох заавар журмын дагуу төсөвт төвлөрүүлж зарцуулах, түрээсийн орлогод тавих дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Дарви сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/155/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дарви сумын ЕБС		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх онд албан шаардлагаар өгсөн бараа материалын тооллого тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, малын нас дэвшлийн тооцоо тооллого хийж албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	104378.0	Дүгнэлтэд нөлөөлөх	Дарви сумын ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч	Б.Баярдалай Н.Бат-Очир
2	Үндсэн хөрөнгийн бүртгэлд хөрөнгийг нэр төрлөөр бүртгэж орлого аваагүй багц дүнгээр бүртгэсэн.	88579.3	Зөвлөмж өгөх		
3	Хүнсний бүтээгдэхүүн болон махны гарал үүслийн бичиггүй, хөрөнгө бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, дотоод хяналт сул байна	8535.5	Зөвлөмж өгөх		
4	Заалны түрээсийн орлого төвлөрүүлж зарцуулаагүй.	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		201492.8			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР